

## **Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний агуулга**

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн талбай, түүний байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга арга хэмжээний төлөвлөгөө
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

№	Товчилсон нэр	Тайлбар
1	БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2	БОАТНДЗ	Байгаль орчны аудитын тайлангийн нэгдсэн дүгнэлт зөвлөмж
3	БОМТХДАХНДЗ	Байгаль орчны менежментийн төлөвлөөний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, зөвлөмж
<b>Хууль тогтоомж</b>		
1	УТХ	Усны тухай хууль
2	АТТХ	Авто тээврийн тухай хууль
3	ХАБЭАТХ	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
4	ГХТХ	Гамшигаас хамгаалах тухай хууль
5	ГАБТХ	Галын аюулгүй байдлын тухай хууль
6	ХХТХ	Хог хаягдлын тухай хууль
7	УБТХ	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль
8	ГТТХ	Газрын төлбөрийн тухай хууль
<b>Стандарт</b>		
1	MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал, усан мандал газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
2	MNS 5914:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
3	MNS 5973:2009	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ
4	MNS 5918:2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
5	MNS 5080:2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
6	MNS ISO 5667-11:2000	Усны чанар – Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж.
7	MNS 6148:2010	Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
8	MNS 0900:2018	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
9	MNS ISO 5667-10:2001	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт.10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
10	MNS 4943:2015	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
11	MNS 3298-90	Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
12	MNS 5850:2019	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын дээд хэмжээ.
13	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

## Нэг. Төслийн товч танилцуулга

Манай компани “Магнетитийн үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн 1га газарт үйл ажиллагаагаа явуулж байна. Үйлдвэр нь жилийн дулаан улиралд буюу 2, 3-р улиралд ажилладаг бөгөөд **улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг.**

Үйлдвэр жилд 10,800 тн магнетит үйлдвэрлэх бүрэн хүчин чадалтай боловч манай улсын зах зээлийн эрэлтээс хамаарч жилд дундажаар 2,100 орчим тонн магнетит үйлдвэрлэдэг жижиг хэмжээний үйлдвэр юм.

Үйлдвэрийн хүчин чадал:

№	Эцсийн бүтээгдэхүүн	Хүчин чадал			
		Цагт	Хоногт	Сард	Жилд
1	Магнетит /тн/	3 тн	72 тн	2160 тн	10,800 тн

2021 онд COVID-оос шалтгаалан ажиллаагүй бөгөөд 2022 онд 1 сар ажиллаж **610 тн** үйлдвэрлэж **487 тн**-ийн нийлүүлэлт хийж жилийн эцсийн байдлаар **123 тн** бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна.

Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн нь **магнетит** бөгөөд уг бүтээгдэхүүнийг нүүрс угаахад ашигладаг.

### Эцсийн бүтээгдэхүүний үндсэн шинж

№	Үзүүлэлт	Чанар
1	Ширхэгийн хэмжээ (-45 micron/325mesh)	≥90%
2	Соронзон чанар (200mT)	≥95%
3	Чийглэг	≤5%
4	Нягт	>4.5 г/см <sup>3</sup>

Манай бүтээгдэхүүнийг нойтон аргаар нүүрс баяжуулах технологитой үйлдвэрүүд ашигладаг бөгөөд одоогийн байдлаар “Энержи Ресурс” ХХК-ийн Ухаа худгийн нүүрс баяжуулах үйлдвэр, “Монголын Алт МАК” ХХК-ийн Нарийн сухайтын нүүрс баяжуулах үйлдвэрүүд ашиглаж байна. Эдгээрээс “Энержи Ресурс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр манай орны магнетитийн зах зээлийн 90%-ийг дангаараа эзэлдэг. Манай бүтээгдэхүүнийг нүүрс баяжуулах үйлдвэрүүд үндсэн түүхий эд болгон ашигладагаараа манай улсын эдийн засгийн болон байгаль орчинд шууд бус чухал ач холбогдолтой. “Энержи Ресурс” ХХК-ийн баяжуулсан эрчим хүчний нүүрс нь “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үндсэн түүхий эд болдог.

Үйлдвэрийн үндсэн түүхий эд нь 65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тул ашигт малтмалд тооцогдохгүй. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүнээ төмрийн хүдрийн баяжмалын үйлдвэрүүдээс худалдан авч ашигладаг.

Үйлдвэрийн үндсэн технологи нь орчин үед дэлхий нийтээр ашиглаж байгаа нойтон аргаар баяжуулах дэвшилтэд тоног төхөөрөмжид суурьлагдсан бөгөөд ямар нэг химийн бодис ашигладаггүй. Үйлдвэрийн технологид ус ашигладаг ба хаягдал усыг усан санд хуримтлуулж дахин ашигласанаар нийт усны хэрэгцээний 98%-ийг эргэлтийн уснаас, 2%-ийг гүнийн худагас авч ашиглаж байна. 1 тн магнетит үйлдвэрлэхэд дундажаар **0.6 м<sup>3</sup>**, жилд дундажаар **1,242 м<sup>3</sup>** газрын доорх ус ашигладаг.

2022 онд ус ашиглуулах дүгнэлтээр нийт 2,000 тн магнетит үйлдвэрлэхэд 1,125 м<sup>3</sup> ус ашиглахаар тооцоологдсон боловч 600 тн магнетит үйлдвэрлэж 698 м<sup>3</sup> газрын доорх ус ашигласан. Энэ нь дүгнэлтэнд заагдсанаас 427 м<sup>3</sup> бага ус ашигласан.

2022 онд үйлдвэрийн бүрэн хүчин чадлын 5.6%-ийг ашиглаж улсын болон орон нутгийн төсөвт нийт 55,235,926 төгрөгний татвар, төлбөр, хураамж төлсөн.

Манай үйлдвэр 2023 онд 4-9 сарын хооронд 6 ажилчны орон тоотойгоор 6 сарын хугацаатай ажиллаж нийт 3,000 тн магнетит үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Үйлдвэрлэлийн ажиллах хүчийг “Эй Эм Жи Эм Ай” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгүүлнэ.

2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний /БОМТ/ биелэлтийн тайланг Говьсүмбэр аймгийн БОАЖГ-д хүргүүлж биелэлтийг дүгнүүлэхэд 90.1 оноотойгоор дүгнэсэн. Аймгийн ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, зөвлөмжид тусгагдсан ажлуудыг 2023 оны төлөвлөгөөнд тусгасан.

2020 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан, БОМТ-г “Мэнд Шүтээн” ХХК-иар хийлгүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар /БОАЖЯ/ батлуулсан. Уг төлөвлөгөөр 5 жилд нийт 11,995,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. 2023 онд БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 31,083,216 төгрөгний зардал зарцуулахаар төсөвлөв.

## Хоёр. Төслийн талбай, түүний байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт


### Төслийн талбай:

Манай үйлдвэр нь үйлдвэрлэлийн зориулалттай 1 га газарт үйл ажиллагаа явуулдаг.



Нэгж талбарын дугаар : 4201004000

Хаяг : Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, ТБЦДС ТӨХК-ийн Багануур Чойр дахь хэсгийн баруун урд



**Үйлдэрийн барилга:** 20м x 60м=1200м<sup>2</sup> – 1ш

**Ажилагсадын байр:** 5м x 40м =200м<sup>2</sup> – 1ш

**Хатаалгын бетон талбай:** 2370м<sup>2</sup>

### Байгаль орчин

**Агаарын температур:** Говьсүмбэр аймаг орчмоор салхины жилийн дундаж хурд 3.2 м/с байна. Жилийн дундаж харьцангуй чийгшил 65%, хөрсний гадаргын жилийн дундаж температур 2.40С байна. Эх газрын эрс тэс уур амьсгалтай ба олон жилийн сарын дундаж температураар 7-р сард хамгийн дулаан +30.4, +35.9 хэм, 1-р сард хамгийн хүйтэн -24, -34 хэмд хүрдэг байна.

Жилийн дундаж хур тунадас зуны улиралд 150-200 мм ба нийт тундасны 75% нь 7-9-р саруудад буудаг. Өвлийн улиралд 75-125мм 10-р сарын дунд үеэс 2-р сар хүртэл алаг цоог цасан бүрхүүлтэй газрын хөрс 1.2м хүртэл хөлдөнө. Магнетитийн үйлдвэрийн талбай нутагт олон жилийн дундажаар салхины хурд 3,5 /сек байна.

**Усны нөөц, онцлог:** Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтах Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамрагдах бөгөөд сав газрын ихэнх хэсэгт тогтмол урсацтай томоохон гол мөрөн байхгүй, гадаргын усны ажиглалт хэмжилтийн сүлжээ, шинжилгээний материал харьцангуй хомс юм. 2014 оны усны тооллогын нэгдсэн дүнгээс харахад сумын хэмжээгээр 1 гол, 4 тойром, 1 булаг, шанд тоологджээ.

Үйлдвэрийн талбайд болон түүний ойр орчимд ямар нэг гол, горхи, тойром, булаг шанд байхгүй.

**Хөрсөн бүрхэвч:** Үйлдвэрийн талбайд Сайргархаг хужирлаг бор хөрсний урвалын орчин сул шүлтлэг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар сулаас дээш чанартай буюу хөрсөнд ямар нэг давслагын зүйл илэрсэн байна. Хөрс ялзмагаар ядуу, бага зэргийн карбонат агуулсан байна. Шим тэжээлийн бодисын агууламжаар дундаас доош хангамжтай, солилцоот суурийн нийлбэрээс кальцийн ион

давамгайлна. Энэ хөрс хөнгөн шавранцарт ойр элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, нийт бүрэлдэхүүнд дунд болон бүдүүн ширхэгтэй элсэн фракци зонхилно, “физик” шавар багатай байна.

Талбайн хөрс нүдэнд харагдах ямар нэгэн химийн бодисоор бохирдоогүй. Хөрс бохирдуулагч элементүүдийн стандартад заагдсан хүлцэх агууламжийн хэмжээнээс бага буюу хөрсөнд агуулагдах хүнд элементүүдийн агууламж зохих норм хэмжээндээ байна.

**Ургамлын аймаг:** Үйлдвэрийн газар нь газрын гадаргуугийн хувьд нам уул толгод, нугачаа элбэгтэй, ухаа гүвээт талын шинжтэй бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1200-1400м-ийн хооронд хэлбэлзэнэ. Эндхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Үйлдвэр орчмын газраар агь үетэн голлосон хуурай хээрийн ургамалшил зонхилж бүрхэц нь 20-40% хүрнэ.

**Амьтны аймаг:** Магнетитийн үйлдвэр орчмын нутаг дэвсгэр нь Ландшафт-биохимийн мужлалаар тал хээр-говийн бүсэд хамаарагдана. Хэдийгээр ой модгүй боловч ургамал, амьтны аймаг баян, олон төрөл зүйлтэй. Мэрэгчдээс үлийн цагаан огтоно, олби, орог саарал, шар сүүлт, туулай, туурайтнаас цагаан зээр, хар сүүлт араатнаас үнэг, хярс, хааяа чоно, шувуудаас бүргэд, элээ, хэрээ, харцага, шар шувуу, болжмор ногтруу, ууль, тагтаа зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчаас могой, хонин ба могой гүрвэл шавьжнаас голио, царцаа, хөх түрүү, соно зэрэг байдаг.

### **Нийгэм эдийн засаг**

**Бүс нутгийн газарзүй:** Сүмбэр сум нь 376,8 мянган га говь, тал, хээр хосолсон газар нутагтай, Засаг захиргааны нэгжийн хувьд 6 багтай Монгол улсын томоохон сумдын нэг юм. /Сумын төвд 3, хөдөөд 3 баг байршдаг/ Сүмбэр сумын 1-р багт Аяганы хонхор, хорих 75, төмөр зам дагуух айлууд харъяалагддаг газар зүйн байрлалын хувьд сумын төвөөс 3 км-ийн зайд оршидог. 2014 оны жилийн эцсийн хүн амын тооллогоор 791 өрхийн 2786 хүн амтай.

**Зам харилцаа:** Үйлдвэрийн талбай нь Говьсүмбэр аймгийн төвөөс 4 км, төмөр зөмын гарамаас 2 км, цахилгаан дамжуулах станцаас 1 км-ийн зайд оршдог.

**Цахилгаан хангамж:** Нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон.

**Дулаан хангамж:** Үйлдвэр нь өвлийн улиралд үйл ажиллагаа явуулдаггүй учир дулаанд холбогдоогүй.

**Бохирын систем:** Ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус хуримтлуулах танктай.

### **Гурав. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

2023 оны БОМТ-нд дараах гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлов. Гол сөрөг нөлөөлөл:

1. Газрын доорх усны нөөц багасах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

1. Эргэлтийн усан сангийн хэвийн ажиллагааг тогтмол хянаж урсгал засварын ажлыг цаг тухайд нь хийгээгүүс хөрс болон хөрсний бага гүний усыг бохирдуулах.
2. Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулах.
3. Түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдсанаас хөрс бохирдох.
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалыг хадгалах, зайлуулах зөв зохистой менежмент хийгээгүүс байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.

### **Дөрөв. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

2023 онд хэрэгжүүлэх БОМТ-нд доорх гол зорилтуудыг тавив. Үүнд:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 300 ш модыг мэргэжлийн байгууллагаар тариулж, сумын байгаль орчны мэргэжилтэнд тоолж акт үйлдэж хүлээлгэж өгөх.
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд эргэлтийн усан сан болон ус дахин ашиглаж байгаа үйлдвэрийн гол тоног төхөөрөмж, шугам хоолойнуудад урсгал засварын ажил хийж гүйцэтгэх.
3. Осол, эрсдлийн менежментийн ажлын хүрээнд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх, гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулах, үйлдвэрийн болон ажилчидын байранд засвар хийх.
4. Хог хаягдалын менежментийн ажлын хүрээнд үйлдвэрийн түүхий эдээс гарах хаягдалыг зохих зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр тээвэрлүүлэхдээ бусад төрлийн хог хаягдалтай тээвэрлүүлэхгүй байх, хогийг ангилан ялгаж дахивар хогийг зохих цэгт өгөх.
5. Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд түүхий эдээс гарах үйлвэрийн хаягдалыг хүнд металлын шинжилгээнд өгч өмнөх онтой харьцуулалт хийх.
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, орон нутгийн 2-оос доошгүй иргэнийг түр ажлын байраар хангах.

**Тав. Сөрөг нөлөөллийг бууруулах арга арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт аргачлал	
	1	3	3	4	5	6	7	8	9	
<b>Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ</b>										
1	Газрын доорх усны нөөц багасах.	Эргэлтийн усан санд урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх.	Усан санд	ш	700,000	1	700,000	4-р сард 1 удаа	MNS 3342:1982. БОМТ 12-13 хуудас.	
2		Ус шүүгч тоног төхөөрөмжид их засварын ажил хийж ус бага ашиглах технологийг үр дүнтэй ашиглах.	Усны нөөц	ш	10,000,000	1	10,000,000	4-р сард 1 удаа		
3		Усны шугам хоолой болон нацоссуудад засварын ажил хийх.	Усны нөөц	ш	1,000,000	1	1,000,000	4-р сард 1 удаа		
4		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө аймгийн БОАЖГ-аар усны дүгнэлтийг гаргуулж, сумын Засаг даргатай гэрээ байгуулж зориулалтын дагуу ашиглах.	Усны нөөц	ш	50,000	1	50,000	4-р сард 1 удаа		УТХ - 28.4. БОАЖ-ын сайдын 2018.10.02-ны А/376 БОМТ 13-р хуудас
5		Ус ашиглалтын тайланг гаргаж хуулийн хугацаанд зохих төлбөрийг төлөх.	Усны нөөц	ш	232,064	1	232,064	12-р сард 1 удаа		УТХ 7.5. БОАТНДЗ 2-р хуудас.
6		Ашиглаж буй усны хэмжээг усны тоолуураар байнга хянах.	Усны тоолуур	ш	-	1	-	Байнга		БОНХ-ийн сайдын 2013.05.16-ны А-156 тушаал. БОМТ 13-р хуудас
7	Эргэлтийн усан сангаас ус хальж газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.	Эргэлтийн усан сан, түүний шугам хоолойг байнга хянах.	Эргэлтийн усан сан	ш	-	1	-	Байнга	БОМТ 12-13 хуудас	
8	Хөрсөн дээр тогтсон ус газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.	Үйлдвэрийн талбайд ус тогтож болзошгүй хонхор газрыг шалгаж шаардлагатай тохиолдолд тэгшлэх.	Үйлдвэрийн хашаан дотор	ш	-	-	-	Байнга	БОМТ 12-13 хуудас	



9	Газрын доорх усны нөөц багасах.	Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаагаар хаягдал усны дүгнэлтийг гаргуулж төлбөрийг хугацаанд нь төлөх.	Хаягдал ус	ш	47,872	1	47,872	12-р сар	УСТХ – 24.2
<b>Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ</b>									
10	Хатаалгын талбай дахь магнетит салхины нөлөөгөөр үйлдвэрийн хашаан дахь хөрс бохирдуулах.	Хатаалга гүйцсэн магнетитийг шуудайд даруй савлах, агуулахад задгайгаар хадгалах.	Хөрс	-	-	-	-	Тухай бүр	БОМТ 11-р хуудас
11	Түүхий эд, бүтээгдэхүүний нөлөөгөөр хөрс бохирдох.	Түүхий эдийг буулгах, бүтээгдэхүүн ачих үед хяналт тавьж ажиллах.	Хөрс	-	-	-	-	Тухай бүр	БОМТ 9-р хуудас
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ</b>									
12	Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулж болзошгүй.	Үйл ажиллагаанд ашиглаж буй машин механизмийг үзлэг оношлогоонд хамруулж шаардлагатай засвар үйлчилгээг хийх.	Квош	ш	30,000	1	30,000	6-р сард 1 удаа	АТТХ-17 ЗГ-ын 2016 оны 213-р тогтоол. БОМТ 11-12 хуудас
13		Үйлдвэрийн барилгад урсгал засварын ажил хийж бүтээгдэхүүн шуудайлах үеийн тоосжилтийг багасгах.	Үйлдвэрийн барилга	ш	2,000,000	1	2,000,000		БОМТ 11-р хуудас
14		Шаардлагатай тохиолдолд үйлвэрийн барилгын дотор болон гадна талбайд урсгал засварын ажил хийж гүйцэтгэх.	Үйлдвэрийн барилга, гадна талбай	м <sup>2</sup>	-	-	-	Тухай бүр	БОМТ 11-р хуудас
	<b>Нийт</b>						<b>14,059,936</b>		

### Зургаа. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сүмбэр сумаас заасан газарт мод тарих.	Хайлаас тарина.	250 м <sup>2</sup>	ш	300	8,000	2,400,000	9-р сард 1 удаа	MNS 5914:2008 MNS 5973:2009 MNS 5918:2008 БОМТ 14-р хуудас БОАТНДЗ 2-р хуудас БОМТХДАХНДЗ №1
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх ургамалжуулна.	Усалгаа хийх нацосс авах	Нөхөн сэргээсэн нийт талбай хэмжээгээр	ш	1	100,000	100,000	5-р сард	БОМТ 14-р хуудас
3		Тарьсан модыг услаж арчилах		ш	1	500,000	500,000	Хавар, намар	
<b>Нийт</b>							<b>3,000,000</b>		

### Долоо. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Үйл ажиллагааны улмаас шууд нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв байхгүй.	Орон нутгийн тахилга, шүтээнтэй уул овоо, түүх соёлын дурсгалт газрыг үйлдвэрийн ажилчдад таниулах.	Сүмбэр сум	1	180,000	180,000	2-р улиралд 1 удаа	БОМТ 15-р хуудас
<b>Нийт</b>				<b>1</b>	<b>180,000</b>	<b>180,000</b>	<b>-</b>	<b>-</b>

### Найм. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Эрүүл мэндээр хохирох.	Ажил гүйцэтгэгч “Эй Эм Жи Эм” ХХК-тай хамтран ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах.	Үйлдвэрийн ажиллагсад	4	240,000	960,000	4-р сард, 1 удаа	ХАБЭАТХ-14.1 БОМТ 16-р хуудас БОАТНДЗ 3-р хуудас
2	Мэргэжлээс шалтгаалах өвчин үүсэх.	Зохих зөвшөөрөл бүхий байгууллагаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэнэ.	Ажлын байранд	1	2,500,000	2,500,000	5-р сард	ХАБЭАТХ-31.2. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тоот тушаал MNS 5080:2001
3	Үйлдвэрлэлийн осол гарах.	Ажил гүйцэтгэгч компанитай хамтран ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх.	Ажлын байранд	1	180,000	180,000	6-р сард 1 удаа	ХАБЭАТХ-28.1.4 Хөдөлмөрийн сайдын 2015 оны а/295 тоот тушаал БОАТНДЗ 3-р хуудас
4		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил гүйцэтгэгч компанид 1 удаа сургалт зохион байгуулна.	Үйлдвэрийн хэмжээнд	1	180,000	180,000	6-р сард 1 удаа	ХАБЭАТХ-17.4 БОМТ 16-р хуудас БОАТНДЗ 3-р хуудас
5		Ажилчдыг хөдөлмөр хамгаалалын хувцасыг өмсөж хэвшүүлэх. Шаардлагатай тохиолдолд шинээр хангах.	Үйлдвэрийн ажиллагсад	6	-	-	Байнга	ХАБЭАТХ-15 БОМТ 16-р хуудас БОАТНДЗ 3-р хуудас
6	Ахуйн байрны стандарт зөрчигдөх.	Ажилчдын халуун усанд орох өрөөг ашиглалтанд оруулах.	Ахуйн байр	1	500,000	500,000	7-р сард 1 удаа	ХАБЭАТХ-3.1.15
		Ажилчдын байранд урсгал засварын ажил хийх.	Ахуйн байр	1	1,500,000	1,500,000	7-р сард 1 удаа	
7	Галын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин хохирох.	Гал түймрээс хамгаалах анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг хангах.	Үйлдвэрийн хэмжээнд	1	-	-	8-р сард 1 удаа	ГАБТХ-17.2.6 БОАТНДЗ 3-р хуудас
8	Аюулт үзэгдэл, ослын улмаас хүний амь нас,	Гамшиг эрсдэлийн тойм судалгаа хийх.	Үйлдвэрийн хэмжээнд	1	180,000	180,000	8-р сард 1 удаа	ЗГ-ын 2018.03.14-ний өдрийн №67 тогтоол

9	эрүүл мэнд хохирох.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах.		1	180,000	180,000	9-р сард 1 удаа	ГХТХ-8.1 МУ-ын Шадар сайдын тушаал 2018.12.07 №120 БОАТНДЗ 3-р хуудас
10	Эрүүл мэндээр хохирох.	Эрх бүхий байгууллагаар ажлын байр, хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламжид ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх.	Үйлдвэрийн хэмжээнд	1	100,000	200,000	5,9-р сард 2 удаа	БОМТ 17-р хуудас
<b>Нийт</b>						<b>6,380,000</b>		

### Ес. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	<b>Ахуйн</b>	Энгийн хог хаягдалын савнуудад ялгах тэмдэг тавих.	Үйлдвэрийн хэмжээнд	ш	3	6,000	18,000	5-р сард	ХХТХ-10.2.1 БОАТНДЗ 3-р хуудас БОМТХДАХНДЗ №4
2		Энгийн хог хаягдалыг ангилан ялгаж дахивар хаягдлыг /шил, лааз, хуванцар г.м/ орон нутгийн дахивар авах цэгт хүргэх.	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	-	-	Тухай бүр	
3		Ахуйн хог хаягдалыг зохих зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр тээвэрлүүлэх.	Үйлдвэрийн хэмжээнд	сар	12	50,000	600,000	Сар бүр	ХХТХ-10.2.4. Сумын ИТХ-ын 2018.12.19-ний 07 тогтоол БОМТ 17-18 хуудас БОАТНДЗ 3-р хуудас
4		Ахуйн бохир усны цэг 70 хувь хүртэл дүүрсэн тохиолдолд зохих	Ахуйн бохир усны цэг	тн	5	11,000	55,000	9-р сард	БОАЖ, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал 2018.04.05

		байгууллагаар тээвэрлүүлэх.							№А/82/128 БОМТ 17-р хуудас БОАТНДЗ 2-р хуудас
5		Сүмбэр сумын ЗДТГ, хамтран нийтийн эзэмшлийн талбайд үүссэн хур хог хаягдалыг цэвэрлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлж актаар хүлээлгэн өгөх.	1-р багийн хэмжээнд	ш	1	500,000	500,000	9-р сард	
6	<b>Үйлдвэрийн</b>	Үйлдвэрийн түүхий эдээс гарах хаягдалыг зохих зөвшөөрөл бүхий аж нэгжээр тээвэрлүүлж, бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлүүлэхгүй байх.	Үйлдвэрийн хаягдал	тн	200	15,000	3,000,000	10-р сард	ХХТХ-10.2.4. Сумын ИТХ-ын 2018.12.19-ний 07 тогтоол БОМТ 18-р хуудас БОАТНДЗ 3-р хуудас. БОМТХДАХНДЗ - №7
7		Үйлдвэрээс гарах дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг ялган авч хоёрдагч түүхий эд авдаг цэгүүдэд тушаах.	Үйлдвэрийн хог хаягдал	тн	-	-	-	10-р сард	ХХТХ-10.2.1 БОАТНДЗ 3-р хуудас
8	<b>Аюултай</b>	Машин механизмаас гарсан аккумулятор, ахуйн хэрэгцээнээс гарах батерей зэргийг ангилан ялгаж түр хадгалах.	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	-	-	-	ХХТХ-23.1.1 БОМТ 18-р хуудас
<b>Нийт</b>							<b>4,173,000</b>		

### Арав. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийлгэх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Тайлбар	Баримтлах стандарт арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>Газрын доорх ус</b>								
1	Усны химийн шинжилгээ	Гүнийн худаг	5, 7-р сар	2	45,000	90,000	Энэ жил үйлдвэр 2 улирал ажиллахаар төлөвлөсөн тул 2 шинжилгээ авахаар төлөвлөв.	MNS ISO 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 0900:2018 БОМТ 22-р хуудас БОМТХДАХНД3 - №5
2	Бохир усны хими, хүнд металл	Эргэлтийн усан сан	6, 9-р сар	2	152,600	305,200	Хаягдал усыг дахин ашигладаг бөгөөд үйлдвэрлэл дууссаны дараа эргэлтийн усан санд хуримтлагдсан усыг 1 удаа хаядаг.	УБТХ - 4.1 MNS ISO 5667-10:2001 MNS 4943:2015 БОАЖ, Сангийн сайдын 2021.12.23-ны А/406/226 хамтарсан тушаал БОМТХДАХНД3 - №5
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
3	Хөрсний механик бүрэлдэхүүн	Талбайн баруун талаас	7-р сар	1	5,000	5,000	Үйлдвэрийн гадна талбайг хөрс хамгаалах зорилгоор бетондсон бөгөөд тухайн талбайн 2 талаас шинжилгээний дээжийг авна.	MNS 3298-90 MNS 5850:2019 БОМТ 22-р хуудас БОАТНД3 2-р хуудас БОМТХДАХНД3 - №5
		Талбайн зүүн талаас	9-р сар	1	5,000	5,000		
4	Хөрсний агрохимийн найрлага	Талбайн баруун талаас	7-р сар	1	10,000	10,000		
		Талбайн зүүн талаас	9-р сар	1	10,000	10,000		
5	Хөрсний хүнд металлын агууламж	Талбайн баруун талаас	7-р сар	1	28,000	28,000		
		Талбайн зүүн талаас	9-р сар	1	28,000	28,000		
		Хог хаягдлын цэгээс	9-р сар	1	28,000	28,000		
<b>Агаарын чанар</b>								
6	Хүхэрлэг хий	Үйлдвэрийн талбай	6-р сар	1	68,500	68,500	Үйлдвэрлэлийн технологийн явцад	MNS 4585:2016 БОМТ 22-р хуудас
7	Азотын давхар эсэл							

8	Нийт тоосонцор		8-р сар				агаарын чанарт нөлөөлөх бодис ялгаруулдаггүй	
9	Дуу шуугиан							
	<b>Нийт</b>					<b>577,700</b>		

**Арван нэг. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

2023 онд үйлдвэрийг “Эй Эм Жи Эм” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээний дагуу явуулах бөгөөд “Шинэ Монгол Магнетит” ХХК-ийн гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор ажиллана. Байгаль орчны удирдлагын тогтолцооны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1	2023 онд ажиллах үйлдвэрлэлийн төлөвлөгөөг батлаж БОМТ боловсруулах, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах зэрэг ажилд ашиглаж биелэлтийг тооцох.	-	4	-	-	Б.Сүх-Очир	Тухайн жилийн үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч ус ашиглалтын хэмжээ өөрчлөгддөг учир төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай.
2	Магнетитийн үйлдвэрлэл явуулах ажил гүйцэтгэх компаниар гэрээ байгуулах.	-	4	-	-		Ажиллах хүчийг ажил гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлдэг учир гэрээ зайлшгүй шаардлагатай.
3	Газрын төлбөрийг хуулийн хугацаанд төлөх.	400,080	4	-	-		ГТТХ-10.1
4	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай байгуулсан хог тээврийн үйлчилгээний гэрээг сунгах.	-	5	-	-		БОАТНДЗ 3-р хуудас.
5	2023 оны БОМТ-г хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар 1 удаа сургалт зохион байгуулна.	180,000	-	6	-		Үйлдвэрлэлийн ажлыг ажил гүйцэтгэгч компаниар хийлгэдэг учир тухайн ажилтнуудад БОМТ-г хэрэгжүүлэх талаар сургалт, зөвлөмж өгөх шаардлага гардаг.
6	Ажил гүйцэтгэгч компанийн БОМТ-г хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь 2 удаа шалгаж бичгээр зөвлөмж, шаардлага тавьж биелэлтийг хянаж ажиллана.	360,000	-	6	8		БОМТ 19-р хуудас
7	Туслан гүйцэтгэгч компаниар орон нутгийн 2-оос доошгүй иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллах ажлыг зохион байгуулах.	-	7	8	9		
8	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацааг сунгуулах.	12,500	-	-	9		ОБЕГ-ын даргын 2012 оны 29-р тушаал.

9	Мод, бут тарихдаа мэрэгжлийн байгууллагаас заавар зөвлөмж авч нутгийн хөрс болон цаг агаарын онцлогт тохирсон мод бут тарих, ургуулах.	-	-	-	9		БОМТХДАХНДЗ - №2
10	Шинээр тарьсан модыг сумын байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчийг байлцуулан тоолж акт үйлдэн баталгаажуулах.	180,000	-	-	9		БОМТХДАХНДЗ - №2
11	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг мэрэгжлийн байгууллагаар хийлгүүлэх.	1,200,000	-	-	9		БОМТХДАХНДЗ - №3
12	Усны нөөц ашигласаны төлбөр болон ус бохирдуулсаны төлбөрийг тухайн онд багтаан аймгийн төсөвт төвлөрүүлэх.	-	-	-	12		БОМТХДАХНДЗ - №6
<b>Нийт</b>		<b>2,332,580</b>					

**Арав хоёр. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө**

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал /төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Багийн иргэд	Танилцуулга материал	БОМТ-ний хэрэгжилт	2023.10.01-2023.11.01	200,000	Захирал Б.Сүх-Очир	Сүмбэр сумын ЗДТГ
2	Аймгийн БОАЖГ	Хэвлэмэл хувь цахимаар		2023.11.01-ний дотор	-		БОАЖГ
3		Газар дээр нь		2023.12.31-ний дотор	180,000		Үйлдвэр дээр
4	БОАЖЯ	Хэвлэмэл хувь цахимаар		2023.12.31-ний дотор	-		БОАЖЯ
<b>Нийт</b>					<b>380,000</b>		



